



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 15 өдөр

Дугаар 1782

Ховд

Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн
зөвлөл байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1.7 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 63 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутагт гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд төр, хувийн хэвшил, салбар дундын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах, бодлогын зөвлөмж гаргах үндсэн чиг үүрэг бүхий гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийг байгуулсугай.

2. Орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга, /дэд хурандаа Б.Алтанбадралт/ нарт тус тус даалгасугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн A/518 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Zax A/232 Ch

02 01143

Ховд аймгийн Засаг даргын
2019 оны 04 дүгээр сарын 15 – ны өдрийн
А/232 дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ОРОН НУТГИЙН
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга

- Аймгийн Засаг дарга

Орлогч дарга

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
- Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга

Нарийн бичгийн дарга

- Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
- Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах Мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч

Гишүүд:

- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга
- Цагдаагийн газрын дарга
- Цэргийн штабын дарга
- Эрүүл мэндийн газрын дарга
- Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал
- Мэргэжлийн хяналтын газрын дарга
- Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга
- Ус цаг уур орчны шинжилгээний газрын дарга
- Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга
- Мал эмнэлгийн газрын дарга
- Боловсрол, соёл урлагийн газрын дарга
- Зооноз өвчин судлалын төвийн дарга
- Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга
- Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга
- Авто тээврийн төвийн дарга
- Аймгийн Улаан загалмайн хорооны дарга
- Одон орон геофизик хүрээлэнгийн ховд салбарын дарга

Ховд аймгийн Засаг даргын
2019 оны 04 дүгээр сарын 15 – ны өдрийн
А/232 дугаар захирамжийн хоёрдугаар
хавсралт

**ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ОРОН НУТГИЙН
ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах, бодлогын зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл (цаашид “Үндэсний зөвлөл” гэх)-ийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Орон нутгийн зөвлөл нь үйл ажиллагаандаа Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журмыг удирдлага болгоно.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1. Орон нутгийн зөвлөлийг аймгийн Засаг дарга тэргүүлж, аймгийн Засаг даргын Тамгын газар, Онцгой байдлын газрын дарга орлоно.

2.2. Орон нутгийн зөвлөл ажлын албатай байна. Орон нутгийн зөвлөлийн ажлын албыг онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга удирдаж, ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагааг тус байгууллагын гамшгийн эрсдэлийн удирдлагын асуудал хариуцсан нэгж эрхэлнэ.

2.3. Аймгийн газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах байнгын ажиллагаатай зөвлөл нь Орон нутгийн зөвлөлийн дэд зөвлөл байна.

2.4. Аймгийн онцгой комисс, гамшгаас хамгаалах улсын албад нь чиг үүргийн хүрээнд Орон нутгийн зөвлөлтэй үйл ажиллагаагаа уялдуулж ажиллана.

Гурав. Орон нутгийн зөвлөлийн бүрэн эрх

3.1. Орон нутгийн зөвлөл нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

3.2. Орон нутгийн зөвлөлийн гишүүн дараах эрхтэй:

3.2.1. шаардлагатай тохиолдолд Орон нутгийн зөвлөлийн ээлжит бус хуралдааныг хуралдуулах санал гаргах.

3.2.2. гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд болон Орон нутгийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжийн хэрэгжилтэд шаардагдах судалгаа, мэдээ, мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах;

3.2.3. гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр хариуцсан салбарт хэрэгжүүлэх арга хэмжээ, салбар хоорондын зохицуулалтыг хангах асуудлыг Орон нутгийн зөвлөлийн хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх.

3.3. Орон нутгийн зөвлөлийн гишүүн дараах үүрэгтэй:

3.3.1. гамшгийн эрсдэлийг бууруулах эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангах, хэрэгжүүлсэн ажлаа Үндэсний зөвлөлийн хурал, холбогдох байгууллага, албан тушаалтанд тайлагнах;

3.3.2. гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой бодлогын зөвлөмж боловсруулах, бусад гишүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж салбар дундын зохицуулалтыг хангах;

3.3.3. Орон нутгийн зөвлөлөөс гарсан шийдвэр, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, холбогдох зардлыг тухайн жилийн төсөвтөө тусгах.

Дөрөв. Орон нутгийн зөвлөлийн хуралдаан

4.1. Орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдааныг орон нутгийн зөвлөлийн дарга зарлан хуралдуулна.

4.2. Хуралдааны дэгийг орон нутгийн зөвлөл батална. Орон нутгийн зөвлөлийн хуралдааны шийдвэр нь зөвлөмж байна.

4.3. Орон нутгийн зөвлөлийн ээлжит хуралдааныг жилд 2-оос доошгүй удаа хуралдуулна. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно

4.4. Ээлжит хуралдааны товыг хуралдаан болохоос 10-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд мэдэгдэж, хуралдааны материалыг тараасан байна.

4.5. Орон нутгийн зөвлөлийн хуралдааныг нийт гишүүдийн 51-ээс дээш хувийн ирцтэйгээр хуралдуулна. Хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг гишүүдийн олонхын саналаар, санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар шийдвэр гаргана.

4.6. Орон нутгийн зөвлөлийн даргын шийдвэрээр Орон нутгийн зөвлөлийн хуралдаанд холбогдох эрдэмтэн, судлаач, мэргэжилтэн, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллөөс оролцуулж болно.

Тав. Орон нутгийн зөвлөлийн чиг үүрэг

5.1 Орон нутгийн зөвлөлийн ажлын алба дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.1.1. Орон нутгийн зөвлөлийн хуралдааны бэлтгэл ажлыг хангаж, хуралдааныг зохион байгуулах;

5.1.2. Орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад гишүүдээс гадна бусад холбогдох талуудыг татан оролцуулах, хяналт тавих;

5.1.3. Орон нутгийн зөвлөлд ирүүлсэн санал, хүсэлтийг хүлээн авч, Орон нутгийн зөвлөлийн хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэх;

5.1.4. Орон нутгийн зөвлөлийн хуралдааны шийдвэрийг холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж тайлагнах;

5.1.5. Орон нутгийн зөвлөлөөс зохион байгуулж байгаа ажил, түүний явц, үр дүнгийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх, сурталчлах;

5.1.6. Үндэсний болон орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагаанд шаардлагатай баримт бичиг, мэдээ, мэдээлэл, судалгааг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдээс гаргуулан авах;

5.1.7. Эрх үүргээ хэрэгжүүлээгүй орон нутгийн зөвлөлийн гишүүд, холбогдох талуудад хариуцлага хүлээлгэх саналыг орон нутгийн зөвлөлийн даргад танилцуулах

5.1.8. Орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах, жилийн үйл ажиллагааны тайланг үндэсний зөвлөлийн ажлын албанд хүргүүлэх

5.1.9. Орон нутгийн зөвлөлийн нарийн бичгийн дарга нар ажлын албаны үйл ажиллагааны хэрэгжилтийг хангахад хамтран ажиллана.

Зургаа. Бусад

6.1. Орон нутгийн зөвлөлийн ажлын албаны үйл ажиллагааны зардлыг орон нутгийн Засаг даргын Тамгын газар, Онцгой байдлын газрын төсвийн хүрээнд санхүүжүүлнэ.

6.2. Орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан арга хэмжээний тухайэ жилийн орон нутнийн төсөв, гамшгаас хамгаалах тухай хуулийн 51.3-т заасны дагуу гамшгийн эрсдэлийг бууруулар сан болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.